

Эрхэлсэн ажилдаа амжилт гарган ажилласан нэр бүхий алба хаагчдад төрийн дээд одон, медаль гардууллаа.

Бүгд Найрамдах Улсыг тунхаглаж, анхдугаар Үндсэн хууль баталсны 100 жилийн ойг тохиолдуулан эрхэлсэн салбартаа олон жил үр бүтээл, идэвх санаачилгатай ажиллаж, эрхэлсэн ажилдаа амжилт гарган ажилласан тус газрын Салбарын бодлого зохицуулалтын газрын Засгийн газрын ахлах референт Н.Мөнхбат, Б.Ганзориг, Засгийн газрын референт Г.Оюунтунгалаг, Хууль, эрх зүйн газрын Засгийн газрын референт Д.Энхцэцэг, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх Б.Ганбат, Хууль, эрх зүйн газрын шинжээч И.Давааноров, Төрийн захиргааны удирдлагын газрын шинжээч Х.Билгүүн нар “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-оор, Төрийн захиргааны удирдлагын газрын шинжээч Н.Нарантуяа “Алтан гадас одон”-оор, Хууль, эрх зүйн газрын Засгийн газрын референт О.Дөлгөөнтуул, Салбарын бодлого зохицуулалтын газрын ахлах шинжээч Б.Очирпүрэв, Засгийн газрын хүний нөөцийн газрын шинжээч П.Баасан нар “Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар тус тус шагнагдлаа.

